



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 08 сарын 02 өдөр

Дугаар 3/49

Ховд

Б.Гантулгыг гэрээт ажилтнаар томилох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 23 зүйлийн 23.2.2 дахь заалтыг үндэслэн
ТУШААХ нь:

1. Ажлын зайлшгүй шаардлагаар Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний асуудал хариуцсан гэрээт ажилтнаар Б.Гантулгыг 2021 оны 08 дугаар сарын 02-31-ний өдрийг хүртэл түр томилсугай.

2. Б.Гантулгыг удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д үүрэг болгосугай.

3. Б.Гантулгыг Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээ”-ний ТҮ-10-5 дахь шатлал буюу 924695 төгрөг (есөн зуун хорин дөрвөн мянга зургаан зуун ерэн тав)-өөр цалинжуулж, ур чадварын нэмэгдлийг 25 хувиар бодож олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ЭНХБОЛД